

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЭДЭЭЛЭЛ

2022.12.03

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хэрэгжилт
1.	Хүн амын өвчлөл, эндэгдлийн мэдээ	Тухай бүр, Хагас жил тутамд	<p>Тайлант хугацаанд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Аймгийн хэмжээнд нийт 615823 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэгт 211851 буюу 34,4 хувь хамрагдаж өмнөх оны мөн үеэс 5,7%-аар буурсан байна.</li> <li>- Жирэмсний эрт үеийн хяналт 96.3 болж өмнөх оны мөн үеэс 0.2%-аар буурсан байна. Эхийн эндэгдэл бүртгэгдээгүй.</li> <li>- Коронавируст халдварт цар тахлын 3988 тохиолдол бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 2.5 дахин буурсан байна.</li> <li>- Халдварт өвчний 4672 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 449,3 промилл ногдож, өмнөх оноос (669.1)-промиллоор буурсан байна. Нийт халдварт өвчний 87,1%-ийг амьсгалын замын халдварт өвчин, 3,2%-ийг бэлгийн замаар дамжих халдварт өвчин, 1,4%-ийг гэдэсний халдварт өвчин, 8,3%-ийг бусад халдварт өвчин тус тус эзэлж байна.</li> <li>- Тайлант хугацаанд сүрьеэгийн өвчлөл 51 бүртгэгдэж, 10000 хүн амд 4,8 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 3,9 промиллоор нэмэгдсэн байна.</li> <li>- Бэлгийн замаар дамжих халдварын 154 тохиолдол бүртгэгдэж нийт халдварт өвчний 3,2%-ийг эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1,7%-аар, 10 000 хүн амд 14,5 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 6,3 промиллоор тус тус нэмэгдсэн байна.</li> <li>- Зүрх судасны өвчлөлөөр нас барсан 185 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 19 тохиолдлоор буюу 2 промиллоор буурсан.</li> <li>- Хорт хавдрын улмаас нас барсан 133 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 9 тохиолдлоор буюу 0.7 промиллоор өссөн. /Үзүүлэлтийг хавсаргав/</li> </ul>
2.	Төрөлт ойртолт, түүний хүн амд эзлэх зохистой харьцааны алдагдал, архи, мансууруулах болон сэтгэцэд хүчтэй нөлөөлөх бодис хэрэглэх, донтох эмгэг, сэтгэцийн эмгэг зан үйл, окуны хомсдолын тухай	Хагас жил тутамд	<p>Аймгийн хэмжээнд сэтгэцийн өвчлөл 2022 оны 11 сарын байдлаар сэтгэцийн ба зан үйлийн эмгэгийн өвчлөл 1560 хүн бүртгэгдсэн нь 10000 хүн амд 146.9 промилл байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 2 промиллоор буурсан үзүүлэлттэй байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Сэтгэцийн өвчлөлд неврозууд ба сэтгэлийн шалтгаант биемахбодын эмгэгүүд 588 тохиолдол буюу 10000 хүн амд 55.3 промиллоор тэргүүлж байна.</li> <li>- Сэтгэц нөлөөт эм, бодисын шалтгаант сэтгэцийн ба зан үйлийн эмгэг (F10-F19)-ийн тохиолдлын тоо 452 бүртгэгдсэн нь 10000 хүн амд 42.5 промилл байна.</li> <li>- Эхний 11 сарын байдлаар сэтгэцийн хөгжлийн саатал F70-79 өвчлөл 77 хүн бүртгэгдсэн. Үүний 45.4 хувийг эрэгтэй, 54.6 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. 2022 оны 11-р сарын байдлаар Амиа</li> </ul>

			<p>хорлолтын тоо 19 буюу 3.8 хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулбал 4 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Сэтгэцийн эмгэгийн амбулаторын хяналтад байгаа хүн 1435 байна.</li> </ul> <p>Ерөнхий боловсролын 5 сургуулийн ахлах ангийн 885 сурагчаас “Өсвөр насны хүүхдийн сэтгэл гутрал, стресс, өөрийн үнэлгээ, цахим хамаарлын түвшин болон түүний гэр бүлийн байдал, оршин суугаа харьяалал хоорондын хамаарлын байдлыг судлахад 55.4% өөртөө итгэх итгэлтэй, 1.8% өөрийн үнэлгээ багатай, 14.4% сэтгэл гутралын хүндэвтэр түвшин, 7.9% сэтгэл гутралын хүнд түвшинд, 33.2% стрессийн түвшин өндөр, 70,9% интернэтийг эрсдэлтэй нөхцөлд ашигладаг гэсэн үр дүн гарсан байна.</p>
3.	Шинэ болон сэргэж байгаа халдварын болзошгүй аюулаас сэргийлэх бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ, халдвар, хордлогын өвчлөл эрсдэлийн тухай	Тухай бүр, жил бүр	<p>Тайлант хугацаанд коронавируст халдварын 3988 тохиолдол бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 340 тохиолдлоор өссөн байна. Коронавируст халдвар илрүүлэх түргэвчилсэн шинжилгээг 22302 иргэнд, Бх-ПГУ шинжилгээг 10422 иргэнд хийсэн байна. Нийт батлагдсан 3988 тохиолдлын ойрын хавьтлын 9548 иргэнд тандалт судалгаа хийсэн. Нийт 70 багц өвчлөл бүртгэгдсэнээс зөөвөрлөгдсөн 25, аж, ахуй нэгж байгууллага 26, найз нөхдийн 19, гэр бүл, хамаатан садны 35 багц өвчлөлийн голомтыг идэвхгүй болсон.</p> <p>Томуу, томуу төст, коронавируст халдварын бэлэн байдал, хариу арга хэмжээний аймгийн хэмжээний төлөвлөгөө боловсруулан салбар байгууллагуудад хүргүүлэн хамтран ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилт 85%-тай байна. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Амьсгалын замын халдварт өвчний үеийн эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, оношлуурын нөөц дунджаар 54 хоногийн нөөцтэй байна.</li> <li>- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн сэргээн засах эмчилгээнд 100.0 сая төгрөг, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 50,0 сая төгрөгийн билиметр болон УВЧ шарлагын аппарат зэрэг шаардлагатай багаж тоног төхөөрөмжөөр хангагдсан.</li> <li>- Улирлын томуугийн эсрэг эсрэг дөрвөн цент вакциныг 13750 хүн тун татан авч, зорилтот бүлгийн 12477 хүнийг хамруулж, хамралт 90,7% байна.</li> <li>- Цар тахлын үед удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллах ЭМА-ыг ЭМГ-ын даргын А/09 дүгээр тушаалаар бүтэц бүрэлдэхүүнийг шинэчлэн томилсон.</li> <li>- Эрүүл мэндийн гамшгийн нөөцийг нэмэгдүүлж Эрүүл мэндийн яамнаас 5 удаагийн 885,3 сая төгрөгийн нөөц хангалт хийгдсэн. Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 690,3 /85,1%/ сая төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэл хамгаалах хэрэгсэл олгож</li> </ul>

			нөөцийг нэмэгдүүлсэн. Эрүүл мэндийн байгууллагуудын нөөц бүрдүүлэлт дунджаар 89,8%-тай, 54 хоногийн нөөцтэй байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 52,1%-аар нэмэгдсэн
4.	Халдварт бус өвчний эрт илрүүлгийн хамрагдалт, хянах эмчлэх үйл ажиллагаа, үзүүлэлтүүдийн тухай мэдээ, тайлан	Хагас жил тутамд	Орон даяар 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс “Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ оношилгоо”-г эхлүүлэн хүүхдийн үзлэгийн 2 насны багцад 37422, насанд хүрэгчдийн 4 насны багцад 68673, нийт 106145 хүн хамруулахаар төлөвлөсөн. Тайлант хугацаанд 24752/23,3%/ иргэн үзлэгт хамрагдсанаас 10326 иргэнд зөвлөгөө өгч, анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хяналтад 813 иргэн, лавлагаа шатлалын эмнэлэгт 2602 иргэнийг шилжүүлсэн байна.
5.	Товлолын болон тархвар зүйн вакцин, биобэлдмэлийн нөөцийн хүрэлцээ, хангамж, устгалын тухай	Тухай бүр, жил бүр	5 удаагийн татан авалтаар товллоор хийгдэх 8 төрлийн 11 халдварт өвчнөөс сэргийлэх вакциныг 40900 хүн тун вакцин татан авсан. Тайлант хугацаанд дархлаажуулалтын хамралт 98,7%-тай байна Товлолын вакцин эхний 10 сарын байдлаар 14965 хүн устгагдсан байна. Үүнд: Тарьдаг саагийн вакцин 6794 хүн тун хугацаа дуусаж, 8171 хүн тун вакцин задалснаас хойш хэрэглэх хугацаа дуусч устгалд орсон. Тархвар судлалын заалтаар 5 төрлийн вакцин 28026 хүн тун вакцин татан авсан бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 2 төрлийн вакцин нэмэгдсэн. Тархвар судлалын заалтаар хийгдэж буй 7562 хүн тун вакцин устгасны 73,4% нь ПФайзер Comirnaty вакцин задалснаас хойш хүн ирээгүй болон 2-8 градуст нэг сараас дээш хугацаа өнгөрсөн шалтгаанаар устгасан. Товлолын вакцины тасалдалгүй ажилласан бөгөөд тархвар судлалын заалтаар галзуугийн вакцин улсын хэмжээнд нөөцгүй болсонтой холбоотойгоор 14 хоног тасарсан байна.
6.	Эм, био бэлдмэлийн аюулгүй байдал, хадгалалт, тээвэрлэлт, экспорт, импортын байдал	Жил бүр	Эм, био бэлдмэлийн бүртгэлийг druginfo.mohs.mn болон LICEMED програмуудад бүртгэж байна. Мөн эм био бэлдмэлийн аюулгүй байдал, тээвэрлэлт, хадгалалтын хувьд Монгол улсын эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, болон бусад холбогдох хууль тогтоомж, стандартыг мөрдлөг болгон ажиллаж байна. Тайлант хугацаанд Эмийн хадгалалт түгээлтэд тавих нийтлэг шаардлага MNS5530:2014 стандартаар 6 ЭХНБ-ыг хянахад 86%, Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS5260:2015 стандартаар 49 нийтийн үйлчилгээтэй эмийн санд хяналт хийхэд 85,2%-тай, жорын маягт, жор бичилтийн MNS5376:2016 стандартаар хянахад дунджаар 82%-тай хянагдсан. Мөн экспорт болон импортод Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар Гаалийн газар, Мэргэжлийн хяналтын газартай хамтран ажилласан.

7.	Эмнэлзүйн лабораторийн гадаад дотоод чанарын хяналтын тухай	Жил бүр	Баян-өндөр Мед нэгдсэн эмнэлгийн онош лаборатори, БОЭТ-ийн лабораторийн нэгдсэн тасаг, Эрдэнэт Медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн онош зүй, лабораторийн тасгууд нь дотоод хяналтыг нийлүүлэгч 3-4 компанийн хяналтыг PCCC1, PCCC2 тестээр хийсэн. Гадаад хяналтыг ХӨСҮТ, SISMEХ компани, Шастины нэрэмжит 3-р эмнэлгийн Австрали улсын гадаад хяналтыг 95-98% чанарын баталгааг хангасан.
8.	Цэргийн насны иргэдийн эрүүл мэндийн төлөв байдлын мэдээ	Жил бүр	Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын 2022 оны 09-р сарын 13-ны А/673-р тоот “Цэргийн жинхэнэ албаны татлагыг зохион байгуулах тухай” захирамжын хүрээнд Цэргийн жинхэнэ албанд татагдагчдад эрүүл мэндийн үзлэг хийх нарийн мэргэжлийн эмч нарыг 9 хүний бүрэлдэхүүнтэй хавар, намар 2 удаа томилон ажиллуулсан. Тус үзлэгээр гэмтэл, нүд, шүд, дотор, мэдрэл, сэтгэц, сүрьеэ, чих хамар хоолой, бэлгийн замын халдварын үзлэг оношилгоо, зүрхний цахилгаан бичлэг, цээжний рентген зураг, бэлгийн замын халдварыг илрүүлэх шинжилгээнүүд хийгдэж ерөнхий эмчийн дүгнэлтийг Цэргийн штабт хүргүүлж ажилласан. 2 удаагийн цэрэг татлагаар нийт 466 цэргийн насны залууст үзлэг шинжилгээ зохион байгуулсан ба эрүүл мэндээр тэнцээгүй 186 буюу 39,9% байна. Үүнд: дотор 38 буюу 8,1%, мэс засал 38 буюу 8,1%, чих хамар хоолой 12 буюу 2,3%, нүд 11 буюу 2,4%, шүд 16 буюу 3,4%, сэтгэц 26 буюу 5,6%, мэдрэл 14 буюу 3%, арьс харшил 9 буюу 1,9%, сүрьеэ 6 буюу 1,3%, жин өндөр 7 буюу 1,5%, тайван цагт цэргийн албанд эрүүл мэндээр тэнцэхгүй 9 буюу 1,9% байна.
9.	Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт, явцын тухай мэдээ, тайлан	Хагас жил тутамд	Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ний өдрийн 314 дүгээр тогтоолоор Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа үндэсний хөтөлбөрүүд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 15-ний өдрийн А/782 дугаар тушаалаар үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан тушаалуудыг хүчингүй болгосон.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

Г.БУДМАА